

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025.06.10

Мөрөн

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл-ийн хувь
ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө/							
ЗОРИЛТ 1. ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА БАЙНА.							
1.1	Хэлтсийн байрны архивын өргөтгөлийн, ажлын зураг, төсөв, бусад баримт бичиг, холбогдох зөвшөөрлийг бүрдүүлэх.	Орон нутгийн төсөв	Хэлтсийн архивын өргөтгөлийн зураг, төсөв, бусад баримт бичиг, холбогдох зөвшөөрлийг бүрдүүлэн ажилласан хувь	-	100	Хэлтсийн архивын өргөтгөлийн ажлыг зохион байгуулах ажлын төсвийг шийдвэрлүүлэх хүсэлтийг Аймгийн Засаг даргад уламжлан, 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон, хэлтсийн даргатай хамтран ажиллах гэрээнд тусгуулсан. Тайлант хугацаанд улсын бүртгэлийн хэлтсийн архивын байрны ерөнхий төлөвлөлтийг хийж, зураг төсвийн тендерийг зарлуулах бэлтгэл ажил хангагдаад байна.	80%
1.2.	Улсын бүртгэлийн цахим гэрчилгээг үйлчилгээнд нэвтрүүлэх	-	Цахимаар олгосон эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний тоо	0	2	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим гэрчилгээ авах 6 хүсэлтийг e.business.mn -ээр илгээснийг хүлээн авч цахим гэрчилгээг баталгаажуулан хүсэлтийг шийдвэрлэсэн байна.	100%
1.3.	Төр, хувийн хэвшлийн байгууллагууд цахим тамга, иргэд тоон гарын үсгийг	-	Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-business, E-mongolia/-аар цахим тамга, тоон гарын үсэг	0	5	Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-business, E-Mongolia/-аар цахим тамга, тоон гарын үсэг ашиглан цахимаар өргөдөл, гомдол, хүсэлт одоогийн байдлаар ирээгүй байна.	100%

	бүртгэлийн үйлчилгээнд таньж баталгаажуулах талаар холбогдох арга хэмжээ авах		ашиглан цахимаар өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авсан тоо				
			Цахимаар хүлээн авсан өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь	0	100	Иргэний улсын бүртгэлийн газраас цахимаар ирүүлсэн нэмэлт өөрчлөлтийн бүртгэл хийлгэх 2 иргэний хүсэлтийг хүлээн авч 1 иргэний хүсэлтийг хүлээн авч Хяналтын улсын байцаагчийн нэгдсэн дүгнэлтээр Иргэний улсын ахлах бүртгэгч нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг хийсэн. 1 иргэний хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй тул буцаасан болно.	100%
1.4.	Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд өгөгдлийн шинжилгээ хийх	-	Үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн тоо	1	4		100%
		-	Шинжилгээний үр дүнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	0	4		
1.5.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	-	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хувь	100	100	2014.07.01-ний өдөр батлагдсан “Шилэн дансны тухай” хууль хэрэгжиж эхэлснээс хойш тус хэлтэс нь хуулийн хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж байна.	100%
		-	Хугацаандаа тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо	171	171	Шилэн дансны сайтад гадаад паспортын шинэчлэгдсэн үйлчилгээний үнэ тариф, 2024 оны аудитын дүгнэлт, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн мэдээ тайланг цаг хугацаанд нь шивэн оруулж тайлант хугацаанд 69 мэдээлэл оруулахаас 69 мэдээллийг хугацаанд нь оруулж 2025 оны 1 дүгээр улирлын шилэн дансны тайланг хуулийн хугацаанд нь илгээгээд байна.	100%
1.6.	Төрийн болон хууль хяналтын байгууллагатай цахимаар мэдээлэл, лавлагаа, хуулбар олгох нөхцлийг бүрдүүлэх.	-	Цахимаар үзүүлсэн лавлагаа, мэдээллийн хувь	-	80	Төрийн болон хууль хяналтын байгууллагатай цахимаар мэдээлэл, лавлагаа, хуулбар олгох үйл ажиллагаа хэрэгжиж эхлээгүй байна.	30%
ЗОРИЛТ 2. ОРЧИН ҮЕИЙН ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭН,							

ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭД ҮЗҮҮЛЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ШУУРХАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.

2.1	Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /киоск/-ийн тоог болон киоскоор үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	-	Киоскоор үзүүлсэн бүртгэлийн үйлчилгээний төрлийн тоо	24	30	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд байршсан 3 киоск машинаас иргэний үнэмлэх дахин захиалгын бүртгэл 2, тоон гарын үсэг олголт 3652 нийт 3654 үйлчилгээ бүртгэгдсэн байна.	100%
			Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /киоск/-ны нэмэгдүүлсэн тоо	3	4	Хөвсгөл аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэст хүсэлт уламжилсаны дагуу “ХУРДАН” киоск машиныг шийдвэрлүүлэн авч хэлтсийн үйлчилгээний зааланд байршууллаа. Мөн Цэцэрлэг сумын ЗДТГ-с төсвийг шийдвэрлэн “New compass” компанитай гэрээ байгуулан, улсын бүртгэлийн киоск машины худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна.	100%
			Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /киоск/-аар үйлчилгээ авсан иргэдийн тоо	13926	15000	Хөвсгөл аймгийн хэмжээнд байгаа улсын бүртгэлийн 3 киоск машины 2 нь Мөрөн суманд хэлтсийн байранд болон, төв Хаан банкны байранд, 1 нь Рэнчинлхүмбэ суманд байршиж байгаа бөгөөд тайлант хугацаанд нийт 4733 иргэн улсын бүртгэлийн киоск машинаас 12 төрлийн лавлагаа авсан байна. Мөн 3522 иргэн киоск машинаас тоонг гарын үсэг авсан байна.	100%
2.2.	Улсын бүртгэлийн үйлчилгээг хөдөлгөөнт хэлбэрээр үзүүлэх /автомашин/ зөөврийн тоног төхөөрөмжийн программ хангамжийг сайжруулах, тоног төхөөрөмжийн	-	Зөөврийн тоног төхөөрөмжийн тоо	2	3	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгын хүрээнд Баянзүрх, Жаргалант, Их-Уул, Рашаант, Цагааннуур, Цагаан-Үүр, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган, Мөрөн сумын Засаг даргын тамгын газарт улсын бүртгэлийн зөөврийн 4G төхөөрөмжийн төсөв шийдвэрлүүлэх хүсэлтийг 2025.01.17-ны өдөр хүргүүлсэн. Хүсэлтийн дагуу 2025.04.12-30-ны өдрийн хооронд гэрээ баталгаажин 4G төхөөрөмжийн 6 212 000 төгрөгийн худалдан авалт хийгдсэнээр 10 сумын 57 багийн 71400 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ хүрч үйлчлэх боломж бүрдсэн.	100%

	тоог нэмэгдүүлэх	-	Улсын бүртгэлийн үйлчилгээг хөдөлгөөнт хэлбэрээр үзүүлсэн иргэдийн тоо	27	30	Хэлтсийн зөөврийн 4G төхөөрөмж ашиглан улсын бүртгэлийн явуулын үйлчилгээг зохион байгуулж Мөрөн сумын “Нутгийн аваргууд” ерөнхий боловсролын сургууль, ШУТИС-н харьяа Хөвсгөл аймаг дахь Политехник коллежийн багш, ажилтан албан хаагч, сурагч нарт цахим гадаад паспортын бүртгэл, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажиллалаа. Мөн Тариалан, Рашаант, Рэнчинлхүмбэ, Цагааннуур сумын улсын бүртгэгч нар зөөврийн 4G төхөөрөмж ашиглан улсын бүртгэлийн явуулын үйлчилгээг зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот бүлгийн 96 иргэнд улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг үзүүлсэн.	100%
2.3.	Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх	-	Эрсдэлийн төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний биелэлтийн хувь	0	100		100%
2.4.	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд Улсын бүртгэлийн багц хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлэхэд санал өгөх	-	Боловсруулсан хуулийн төсөлд санал өгсөн тоо	-	4	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлын хүрээнд Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд тусгах саналыг нэгтгэн 2025 оны 01 дүгээр сарын 15 болон 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт тус тус хүргүүлсэн.	100%

2.5.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг харьяалал харгалзахгүй бүртгэх талаар холбогдох арга хэмжээ авах	-	Харьяалал харгалзахгүй бүртгэсэн хуулийн этгээдийн тоо	-	2	Хуулийн этгээдийн харьяалал харгалзахгүй бүртгэл хөтөлж эхлэх хууль хэрэгжиж эхлээгүй, програмын өөрчлөлт хийгдээгүй болно. Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах 2000 гаруй хүсэлт e-business болон улсын бүртгэгчид ирснийг харьяалал харгалзахгүй баталгаажуулж ажиллалаа.	100%
2.6.	Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх	-	Иргэний улсын бүртгэлийн тоо	47054	48000	Тайлант хугацаанд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 24790 бүртгэл хөтөлсөн байна.	100%
		-	Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлсөн тоо	1066	800	Тайлант хугацаанд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 804 материал хүлээн авч бүртгэл хөтөлсөн байна.	100%
		-	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн тоо	13416	13000	Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт 5297 мэдүүлэг хүлээн авч, холбогдох бүртгэлийг хөтлөн ажилласан.	100%
2.7	Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх	-	Сар бүр иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх инфографик мэдээллийг бэлтгэн брошур хэлбэрээр байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан тоо;	12	12	Тус хэлтсийн 1-5 дугаар сарын иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаар 5 удаагийн инфографик мэдээллийг үнэн зөв гарган тус, хэлтсийн цахим хуудас болон хэлтсийн ил тод байдлын самбар, олон нийтийн сүлжээнд байршуулсан. Хэлтсийн цахим хуудас, фейж хуудас, shilen.gov.mn сайтаар дамжуулан 106 удаагийн давтамжтайгаар иргэд олон нийтэд сурталчлан ажиллаад байна.	100%
2.8	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих ажлыг сайжруулах.	-	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн хувь	100	100	Тайлант хугацаанд хэлтсийн хэмжээнд иргэдээс 172 өргөдөл, гомдол хүлээн авч 100% шийдвэрлэсэн бөгөөд 1,2 дугаар улирлын өргөдөл гомдлын мэдээг УБЕГ-т хугацаа хоцроолгүй үнэн зөв хүргүүлэн ажиллаж байна.	100%
2.9	2025 оныг хэлтсийн хэмжээнд “Архивын жил”	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100	Хэлтсийн 2025 оны үйл ажиллагааг “Архивын жил” болгон зарласантай холбогдуулан 8 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр хэлтсийн даргаар батлуулан эхний хагас	

	болгон төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллах.					жилийн байдлаар хэрэгжилтийг 100% ханган ажиллаж байна. Хэлтсийн архивын зориулалттай 2 өрөө нь архивын баримт бичгийг хадгалах даацаас хэтэрсэн тул зориулалтын бус бүртгэгчийн өрөө болон 00н өрөөг тохижуулан архивын баримтыг хадгалж байна. Мөн архивын өрөөний тавиур хүрэлцэхгүй хувийн хэрэг багтахгүй нөхцөл байдал үүссэн тул эхний ээлжинд архивын тавиурын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.	100%
2.10	Гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид үзүүлэх	10 сая төгрөг	Гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй сумын тоо	8	10	Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, алслагдсан сум, багийн иргэдэд Улсын бүртгэлийн үйлчилгээг ойтуулах ажлын хүрээнд “ГАРТ ОЙР-ГЭРТ ОЙР-ГАДААД ПАСПОРТ” арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2024 онд 8 сум цахим гадаад паспортын бүртгэл хөтөлж байсан бол тайлант хугацаанд 2 сум нэмэгдэж гадаад паспортын үйлчилгээг иргэдэд үзүүлж эхэлснээр үндэсний энгийн цахим гадаад паспортын бүртгэлийг 10 сум хөтөлж байна. Тайлант хугацаанд суманд захиалагдсан цахим гадаад паспортын 660 бүртгэл хөтлөгдсөн.	100%
2.11	Сум, багт хүрч үйлчлэх зөөврийн компьютер, сүлжээний төхөөрөмж шийдвэрлүүлэх	Орон нутгийн төсөв	Зөөврийн компьютер, сүлжээний төхөөрөмж шийдвэрлүүлсэн сумын тоо	-	5	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгын хүрээнд 10 сумын Засаг даргын тамгын газартай хамтран ажиллаж зөөврийн 4G төхөөрөмжийн 6 212 000 төгрөгийг шийдвэрлүүлэн сүлжээний төхөөрөмжийн худалдан авалт хийгдсэн. Мөн улсын бүртгэлийн үйлчилгээнд ашиглагдах зөөврийн компьютерийг худалдан авах гэрээг Алаг-Эрдэнэ, Рашаант, Тосонцэнгэл, Цагааннуур, Цэцэрлэг сумын ЗДТГ “Агуу хангай” ХХК-тай байгуулан эхний ээлжинд Цагааннуур сумын зөөврийн компьютерийг хүлээлгэн өгөөд байна.	100%
2.12	Алслагдсан сум багт хүрч үйлчлэх зорилгоор туулах чадвар сайтай	25 сая төгрөг	Шийдвэрлүүлсэн машины тоо	0	1	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Д.Пүрэвдоржид хэлтсийн албан хэрэгцээнд шаардлагатай туулах чадвар сайтай авто машин шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг уламжлан ууз	100%

	машин шийдвэрлүүлэх					фургон машин шийдвэрлүүлсэн. Тухайн авто машиныг хэлтсийн үндсэн хөрөнгөнд авах тухай зөвшөөрлийн хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн ажиллаж байна.		
ЗОРИЛТ 3. УЛСЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НЭГДСЭН САНГИЙН НУУЦЛАЛЫГ ХАНГАН, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.								
3.1	Цахим мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг ханган ажиллах	-	Мэдээллийн сүлжээний байдал, төхөөрөмжийн ажиллагааг ажигласан тоо	нэгдсэн аюулгүй тоног хэвийн ханган	4	4	Хэлтсийн албан хаагчид “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ын хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж байгаад хяналт тавих, цаашид өдөр тутмын бүртгэлийн үйл ажиллагаанд журмын хэрэгжилтийг хангуулан ажиллуулах зорилготой удирдамжийг хэлтсийн даргаар батлуулан 2024.12.06 болон 2025.04.11-12-ны өдөр гэнэтийн шалгалт зохион байгуулж, албан хаагчдад зөвлөгөө, чиглэл хүргүүлэн ажиллаж байна. Мөн хэлтсийн албан хаагчдаас ирүүлсэн 27 удаагийн засвар үйлчилгээ, програм, бүртгэлийн сүлжээтэй холбоотой дуудлага хүлээн авч, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангасан.	100%
3.2	Улсын бүртгэлийн хэлтсийн компьютер, түүний дагалдах техник тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэн сайжруулах.	-	Төлөвлөгөөнд тусгагдсан төхөөрөмжийг шинэчилсэн тоо	тоног	0	2	2025 оны 04 дүгээр сарын 17-18-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Мэдээлэл технологийн албан хаагч нарт мэдлэг олгох” сургалтын үеэр хэлтсийн мэдээлэл технологийн ажилтны зөөврийн компьютер үйл ажиллагаанд шаардлагатай сүлжээний утас, багаж зэргийг шинэчлэсэн.	100%
ЗОРИЛТ 4. ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭН, ГАДААД ОРНЫ БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУРШЛАГААС БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГТ ТОХИРУУЛАН ХЭРЭГЖҮҮЛНЭ.								
4.1.	Эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн системийг	ADB төсөл	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /ePRS/-ийг шинэчлэх хувь		0	80	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /ePRS/-ийг шинэчлэх тухай саналыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.	50%
		ADB төсөл	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим		0	80	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим систем /eRS/-ийг шинэчлэх тухай саналыг Хуулийн	50%

	шинэчлэх ажлыг эхлүүлэх.		систем /eRS/-ийг шинэчлэх хувь			этгээдийн улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.	
ЗОРИЛТ 5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
5.1.	Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх.	-	Хэрэгжилтийг хангасан хувь	0	100	Хэлтсийн 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 8 арга хэмжээтэйгээр 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Аймгийн засаг даргын тамгын газарт Авлигын эсрэг үйл ажиллагааны тайлангийн биелэлтийг хуулийн хугацаанд нь хүргүүлсэн.	100%
5.2	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчийн мэдээллийн нээлттэй мэдээллийн стандартаар ил тод болгож, тогтмол шинэчлэх /4.3.1.2/	-	Нээлттэй мэдээллийн стандартаар ил тод болгосон хуулийн этгээдийн хувь	0	80	Хуулийн этгээдийн шинээр байгуулагдсан 480, эцсийн өмчлөгчөө өөрчлөн болон нөхөн бүртгүүлсэн 93 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчөөр бүртгүүлсэн байна. Эцсийн өмчлөгчийн бүртгэл нь opendata.burtgel.gov.mn сайтад нээлттэй мэдээллийн стандартаар ил тод байршсан болно.	100%

5.3.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	-	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо	16	18	Авлигатай тэмцэх газрын пэйж хуудсанд байршуулсан бүртгэлийн салбарын ажилтан албан хаагчдыг авлигын сургалтанд хамруулав, үндэслэлгүй хөрөнгөжих цувралын 2 дугаар, 2024 онд хийсэн онцлох ажлуудаас, Eagle TV Иргэний мэдээ, хаалган хадны нууц хүүхэлдэйн жүжиг, үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам хянав, төрийн зарим байгууллагын цахим хуудасны ил тод байдалд дүн шинжилгээ хийв, авлигатай тэмцэх гадаад хамтын ажиллагаа, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн талаар гэсэн сэдвээр бэлтгэсэн 10 контент, нэвтрүүлэг байгууллагын пэйж хуудсанд хуваалцаж олон нийтэд мэдээллээ. Мөн Авлигын эсрэг үйл ажиллагааны “Авлигын эсрэг нэгдье 110” мэдээлэл, санал асуулгын хайрцгийг байгууллагын үйлчилгээний зааланд байршуулан сар бүр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой хориглолт, албан тушаалаас чөлөөлөгдсний дараах хязгаарлалт, сурталчилгаатай холбогдсон хязгаарлалт, бусад орлогын хязгаарлалт, төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт, улс төрд нөлөө бүхий зарим этгээдэд тавигдах хязгаарлалт, хандив авахтай холбогдсон хязгаарлалт, бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт, давхар ажил эрхлэлттэй холбогдсон хязгаарлалт, шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох зэрэг гарын авлага материалуудыг байршуулж байна.	100%
		-	АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулсан тоо	3	5	2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн Авлигатай тэмцэх газар болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн тасгийн хамтарсан сургалтад Иргэний улсын бүртгэлийн тасгийн албан хаагчид хамрагдсан.	

ЗОРИЛТ 6. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.

6.1	Эцсийн өмчлөгчийн мэдээллийн чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах	-	Албан хаагчдыг чадавхижуулах сургалтад хамрагдсан тоо	0	1	Эцсийн өмчлөгчийн мэдээллийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд албан хаагчдыг чадавхижуулах сургалтыг Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулахаар сургалтын хөтөлбөр ирсэн боловч тодорхой шалтгааны улмаас хойшилсон болно.	100%
ЗОРИЛТ 7. ЧАДАХУЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЖ, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА.							
7.1	Хэлтсийн 2025 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Хэлтэст зохион байгуулах 2025 оны сургалтын төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр 11 арга хэмжээтэй боловсруулж хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу холбогдох сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газраас болон аймгийн ЗДТГ, бусад байгууллагаас зохион байгуулсан нийт 26 удаагийн сургалтад хэлтсийн бүх албан хаагчид болон хэлтсийн дарга, холбогдох албан хаагчид бүрэн хамрагдсан байна. Мөн аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучууд хөгжлийн газар, Хилийн цэргийн 0257 дугаар анги, Нийгмийн даатгалын газар, Прокурорын газар, Монгол банк, Төрийн банк, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Онцгой байдлын газар, Тагнуулын ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь хэлтэс, Титэм ЕБС, Авьяас ЕБС зэрэг байгууллагуудтай хамтран сургалтыг хэлтсийн албан хаагчдад танхимаар зохион байгуулсан.	100%

7.2	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	-	95	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 17 арга хэмжээтэйгээр 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж байна. /Хэрэгжилтийг үйл ажиллагааны бичмэл тайланд оруулсан./	100%
7.3	Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлж эхлэх	-	Албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлсөн хувь	0	100	Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлж эхлэх зорилтын хүрээнд “Хэлтсийн албан бичгийг кирилл болон үндэсний бичгээр хослуулан хөтөлж” 2 зорилт 8 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдөр хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэлтсийн даргын тушаал болон ирсэн явсан бичгийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлж ажиллаж хэвшсэн.	100%
7.4	Улсын бүртгэлийн хэлтсийн зөрчил гаргасан алба хаагчдад сахилгын болон ёс зүйн хариуцлага хүлээлгэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авах	-	Хариуцлага хүлээлгэсэн хувь	0	100	Тус хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Ням-Одjarгалд холбогдох иргэн Б.Магсарын гомдол 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргад гаргасан байна. Тухайн гомдлыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын ёс зүйн дэд хороо хүлээн авч ёс зүйн дэд хороо 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр хуралдаж тухайн иргэн Б.Магсарын гомдлыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 19 дугаар дүгнэлтээр “Ёс зүйн зөрчилд тооцохгүй тухай”цд тооцсон байна.	100%
7.5	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/116 дугаар тушаалаар	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/116 дугаар тушаалаар баталсан “Эрдэмт Монгол” зорилтот арга хэмжээний төлөвлөгөөний эхний шатны хэрэгжилтийг ханган 2025 оны эхний хагас	100%

	баталсан “Эрдэмт Монгол” зорилтот арга хэмжээний төлөвлөгөөний эхний шатны хэрэгжилтийг хангах					жилийн байдлаар 3 үйл ажиллагааг 100 хувь ханган ажилласан. /Арга хэмжээний биелэлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн/	
7.6	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/110 дугаар тушаалаар баталсан “Хамгийн чухал нь” зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Үзлэг, оношлогоонд албан хаагчдын хамрагдсан хувь	-	100	Хууль зүй дотоод хэргийн салбарын орон нутгийн алба хаагчдын эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийн эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн “Хамгийн чухал нь” зорилтот арга хэмжээ тус аймагт 2025 оны 01 дүгээр сарын 08-12-ны өдрийн хооронд зохион байгуулагдаж тус хэлтсийн 21 албан хаагч, гэр бүлийн 15 гишүүн нийт 36 хүнийг хамруулан ажилласан.	100%
7.7	“Тэрбум мод” хөдөлгөөнийг хэрэгжүүлэх	-	Шинэ модны тоо	150	100	2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Хөвсгөл аймгийн Мөрөн сумаас хойш 5 км-т байрлах Соёмбо цогцолборт “УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТӨГӨЛ” байгуулж тохижууллаа. Төгөлд: Хайлаас 50 ширхэг, Голт бор 25 ширхэг, Монос 10 ширхэг нийт 85 мод тарьсан. Төгөлийг арчилж ургуулах ажлыг тасралтгүй зохион байгуулж хэлтсийн нийт албан хаагчдыг хамруулан “Төгөл услах хуваарь” гарган ажиллаж байна.	100%
		-	Нөхөн тарилтын хувь	-	100		

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Төвлөрүүлэн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(албан тушаал)

..... /У.БОЛДХҮҮ/
(гарын үсэг)
2025.06.10
Тэмдэг

Төлөвлөгөө тайлагнасан:

Төсвийн Шууд захирагч

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)

..... /Б.МӨНГӨНЗУЛ/
(гарын үсэг)
2025.06.10
Тэмдэг